

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/2 дугаар зүйлийн 2.1.5, 2.1.6 дахь заалт:**

“2.1.5.ажилгүйдлийн тэтгэмж;  
2.1.6.шимтгэлийн хөнгөлөлт.”

**2/4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг:**

“4.3.Энэ хуулийн 4.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхойлно.”

**3/7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг:**

“7.3.Жирэмсний тэтгэмжийг төрөхийн өмнөх 60 хоног, амаржсаны тэтгэмжийг төрсний дараах 60 хоног, ихэр хүүхэд төрүүлсэн бол 80 хоногийн доторх ажлын өдрөөр тус тус тооцож олгоно.”

**4/7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг:**

“7.4.Энэ хуулийн 7.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхойлно.”

**5/10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг:**

“10.3.Энэ хуулийн 10.1-д заасны дагуу тооцсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг 21-д хувааж ажилгүйдлийн тэтгэмж бодох нэг өдрийн дундаж цалин хөлсийг тодорхойлно.”

**2 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “шимтгэлийн төлбөрийг олгоно:” гэснийг “шимтгэлийн төлбөр, хөнгөлөлтийг олгоно:” гэж, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “авч байсан” гэсний дараа “энэ зүйлийн 8.1-д заасан нөхцөлийг хангасан” гэж, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “жагсаалт, тэтгэмж” гэсний дараа “тооцож” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"11.1.Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг ажлаас чөлөөлөгдсөний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрөөр, харин өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн бол ажлын 55 өдрөөр тооцож тус тус олгоно."

**4 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн "9" гэснийг "12" гэж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийн "3" гэснийг "9" гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн "9" гэснийг "12" гэж, мөн зүйлийн 10.2 дахь хэсгийн "9" гэснийг "12" гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн "ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж гаргуулаагүй," гэснийг "тэтгэмжийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж гаргуулаагүй" гэж, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн "ажилгүйдлийн" гэснийг "тэтгэмжийн" гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг хассугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийн 3, 4 дүгээр зүйлийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ